

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч, Одонмажиг Марина

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1. Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;							
1	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Явцын тайлангийн тоо /тоо/	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, танилцуулгыг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1961 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2024 оны явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Эдийн засаг, хөгжлийн яаманд хамаарах 115 заалтын 2025 оны 10- дугаар сарын байдлаарх хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн	Тайлангийн тоо /тоо/	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын 2024	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 2024	Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 1-р	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

195

	хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ		оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/1615 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	хавсралтад тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 5 жил тутам(дуусгавар болохоос 1 жилийн өмнө)тайлагнаж, ХШҮ хийхээр зохицуулсан байна.	сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2023 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/133 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны хэрэгжилтэд хамаарах 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталснаас 243 арга хэмжээний тайлан, шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2024 оны явцын дундаж үнэлгээ 77.5 хувийн биелэлттэй гарсан. Нийт 94	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

10/21

					<p>шалгуур үзүүлэлтийг үндсэн хэрэгжүүлэх 25 байгууллагаас явцын тайланг ирүүлэхээс 12 байгууллага 88 шалгуур үзүүлэлтийн 2024 оны явцын тайланг ирүүлсэн Үүнээс 18 шалгуур үзүүлэлтийг тайлагнах хугацаа болоогүй, 5 шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй буюу тооцох аргачлал тодорхойгүй тул 65 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дунджаар 62.3 хувьтай үнэлэгдлээ. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 243 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс 580.1 тэрбум төгрөгөөр 67 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжаас 1.277 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 20.0 тэрбум төгрөгөөр 1 арга хэмжээ, орон нутгийн сангаас 12.6 тэрбум төгрөгөөр 8 арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангаас 145.5 тэрбум төгрөгөөр 7 арга хэмжээ,</p>	
--	--	--	--	--	--	--

					бусад эх үүсвэрээр 6.496.3 тэрбум төгрөгөөр 8 арга хэмжээ тус тус санхүүжигдсэн байна. Нийт төсөл арга хэмжээний үнэлгээг журмын 6.2.3-д заасан. ангилалд шилжүүлэн тооцвол 15.6 хувь нь "Үр дүнтэй", 40.3 хувь нь "Тодорхой үр дүнд хүрсэн", 38.3 хувь нь "Эрчимжүүлэх шаардлагатай", 5.8 хувь нь "Үр дүнгүй" байна. Хавсралт: 1 файл		
4	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ	Тайлангийн тоо	"Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/133 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. Батлагдсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 59.8 хувийн хэрэгжилттэй гарсан. Үүнээс бүрэн хэрэгжиж дууссан 48 төсөл байгаа бол хангалтгүй буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 38	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					төсөл байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөл, арга хэмжээнд 2024 онд нийт төсөвт өртгийн 6.8 хувь буюу 3.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 32 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн дүнгийн 87.1 хувь буюу ойролцоогоор 3.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн байна.		
5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Тайлангийн тоо /тоо/	Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн биелэлт, 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 06-р сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Сар бүрийн хэрэгжилтийг цахим системээр тайлагнасан.	Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2024 оны жилийн эцэс, 2025 оны хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /2 тайлан/	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан нийт 28 арга хэмжээний хэрэгжилтэд ХШҮ хийж, хэрэгжилтийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын и-мэйл хаяг monitoring@ags.gov.mn-аар хүргүүлж ажилласан. Арга хэмжээний хэрэгжилт 97.1% тай үнэлэгдсэн. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан үндсэн 59 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлсэн 144 арга хэмжээг Засгийн газрын 43-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					р тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1-т заасан аргачлалын дагуу дүгнэсэн бөгөөд төсөл арга хэмжээний хэрэгжилт 91.2 хувь, буюу "үр дүн гарсан" байна. Тайланг 2025.07.01 өдөр 03/1765 дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн Хавсралт: 1 файл		
6	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Тайлангийн тоо /тоо	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/105, 2024 оны 06-р сарын 24-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн.	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. /2 тайлан/	"Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалыг нэгтгэн "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулга, холбогдох тайлангийн хамт Хяналт үнэлгээний үндэсний хороонд 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/132 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан. "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 194 төсөл арга хэмжээ, 205	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.1 хувь буюу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 20.1 хувь буюу 39 төсөл арга хэмжээ үр дүнтэй, 19.5 хувь буюу 38 төсөл, арга хэмжээ 11 тодорхой үр дүнд хүрсэн, 52.5 хувь буюу 102 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 7.7 хувь буюу 15 төсөл, арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасан хугацаанд буюу 2025 оны 07 дугаар сарын 10-нд ЗГХХГ-т 03/1765 дугаартай албан бичгээр албажуулан хүргүүлсэн байна.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
7	Яамны эрхлэх	Тайлангийн	Яамны эрхлэх	Яамны эрхлэх	Яамны эрхлэх асуудлын	1-р сар, 2-	100%

	асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	тоо /тоо	асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цахим системээр тайлагнасан байна. /2 тайлан/	хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар тайлагнан баталгаажуулж, 2025 оны 01-р сарын 15-ны өдрийн 01/132 албан тоотор ЗГХХГ-т хүргүүлсэн. 2. Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан танилцуулгыг 2025 оны 7 дугаар сарын 1-ны өдрийн 03/1765 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. Хавсралт: 2 файл	р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
8	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт	-	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 3 дугаар сарын 15-ны 01/528 тоот албан бичгээр	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн	"Аймаг, нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийн 2024 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 82.5 хувийн биелэлттэй гарсан бөгөөд нийт 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 38.3 хувь нь "үр дүнтэй" 48.2	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	хүргүүлнэ.		ЗГХЭГ-т хүргүүлсэн.	байна. /1 тайлан/	хувь нь "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн бол 11.6 хувь нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, "эрчимжүүлэх шаардлагатай", 1.8 хувь нь "үр дүнгүй" гэж үнэлэгдсэн. Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 181 аймаг, нийслэлийн хэмжээнд 3.07 их наяд төгрөгийн төсвийг зарцуулахаар төсөвлөж, гүйцэтгэлээр 3.33 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан танилцуулгыг 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 01/677 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж ажилласан. Хавсралт: 1 файл	сар	
9	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад	Хэрэгжилтийн явц, хувиар	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд байгуулах гэрээ болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний	Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд байгуулах гэрээний төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд санал өгсөн. Хөгжлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р	100%

	хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.		төслийн шалгуур үзүүлэлтэд санал өгсөн	оновчтой тодорхойлоход санал хүргүүлнэ. /100 хувь/	бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлохдоо богино хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр тухайн жилд үр дүн нь гарах үзүүлэлт байхаар тодорхойлох талаар Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт санал хүргүүлсэн	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
10	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийнэ	Тайлангийн тоо /тоо	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн ба тайланг яамны удирдлагад 2024 оны 06 дугаар	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж яамны удирдлагад танилцуулсан байна. /1 тайлан/	2024 онд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 7 төсөл, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 1 төсөл, гадаадын зээлээр хэрэгжсэн 1 төсөл нийт 9 төсөл хэрэгжиж байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн нийт 9 төслийн 2 төсөл нь "тодорхой үр дүнд хүрсэн" буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй ч, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, үр дүнг нэмэгдүүлэх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

122

			сарын 07-ны өдөр танилцуулсан.		шаардлагатай, 5 төсөл нь "эрчимжүүлэх шаардлагатай" буюу зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байгаа бол 2 төсөл нь "үр дүнгүй" буюу зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй гэсэн үнэлгээтэй гарлаа. Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2024 онд гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 41.1 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2025 оны 02 сарын 28-ны 01/598 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
11	Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд	Тайлангийн тоо /тоо/	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй "Эдийн засгийн хамтын	Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	100%

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.		ажиллагааны бүс хөгжүүлэх" төслийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2024 оны 02 дугаар сарын 29-ны 01/438 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна. /1 тайлан/	үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.6.6-т "Захиргааны байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 7 төсөл, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 1 төсөл, гадаадын зээлээр хэрэгжсэн 1 төсөл нийт 9 төслийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ 2025 оны 02 дугаар сарын 28- ны өдрийн 01/598 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц 41.1 хувьтай байна Хавсралт: 1 файл	сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
12	Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Тайлангийн тоо /тоо	Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2023 оны гэрээний хэрэгжилтэд	Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилтэд	Эдийн засаг, хөгжлийн сайдаас Засаг дарга нартай байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд гэрээний гуравдугаар хавсралт дахь "хяналт-шинжилгээ,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	100%

			хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газарт хүргүүлсэн	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргасан байна. /1 тайлан/	үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-ий дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 86.69 хувьтай үнэлэгдсэн. Тайлан танилцуулгыг 2025-02 дугаар сарын 28-ны өдрийн 01/588 албан тоотоор ЗГХХГ-т хүргүүлсэн Хавсралт: 1 файл	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
13	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ	Тайлангийн тоо /тоо/	Тус яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/	Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/4560 дугаартай албан бичгээр Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95.7 хувьтай үнэлэгдсэн ба яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" А/269 дугаар тушаалаар тайлант онд 24 зорилтын хүрээнд 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 101, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хувийн хэрэгжилттэй 34, 70 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ байсан байна. Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт 99.3 хувьтай үнэлэгдсэн байна.		
14	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийнэ	Хэрэгжилтийн явц, хувиар	Тус яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө шинэчлэн батлагдсан. Үүний дагуу 2024 оны 4 дүгээр улиралд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр холбогдох албан тушаалтанд танилцуулсан.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, яамны удирдлагад танилцуулсан байна. /100 хувь/	Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын 2025 оны хяналт шалгалт, дотоод аудит хийх ажлын төлөвлөгөөний дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд харьяа байгууллагын /Шинжлэх ухаан технологийн сан, Оюуны өмчийн газар, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн/ 2025 оны 09 сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд харьяа байгууллагын /Үндэсний хөгжлийн хүрээлэн, Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв/-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашид гарч болох эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн үйл ажиллагаа, хууль тогтоомж, бусад журам эрх зүйн актын хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж өгч	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ажилласан. Тайланг удирдлагад танилцуулж, хувийг 2025.11.07-ны өдрийн 02-3040 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
15	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт шалгалт хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, яамны удирдлагад танилцуулсан байна. /100 хувь/	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 онд баталсан "Хяналт шалгалт, дотоод аудит хийх тухай" удирдамжийн хүрээнд "Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн", "Шинжлэх ухаан технологийн сан", "Оюуны өмчийн газар", "Үндэсний хөгжлийн хүрээлэн", "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв"-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж харьяа байгууллагуудад 2025.11.07-ны өдрийн 02-3040 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
16	Байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Байгууллагын 2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2024 оны 5 дугаар сард хяналт шинжилгээ хийж, яамны удирдлагад 5 зөвлөмж бүхий	Байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, яамны удирдлагад танилцуулсан байна. /100 хувь	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 1-31-ны хооронд харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд аудит	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%

			тайланг танилцуулсан.		хийж танилцуулсан. тайланг Дотоод цаашид гарч аудитаар болзошгүй эрсдэлээс сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулах хүрээнд Шинжлэх ухаан технологийн санд 16 зөвлөмж, Оюуны өмчийн газарт 9 зөвлөмж, Уламжлалт анагаах ухааны хүрээлэнд 6 зөвлөмж өгч ажилласан. Сангийн сайдын 2025 оны 01/10084 дугаартай "Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай" албан бичгийн дагуу яам болон харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудас хөтлөлт, хуулийн хугацаандаа мэдээллийг байршуулсан эсэхэд хяналт хийж, үр дүнг нэгтгэн тайланг хүргүүлсэн.	сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	-----------------------	--	---	-------------------------	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Арга хэмжээний нэр, дугаар 4.1.1. Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	-	-	1.Удирдлагын академийн "Төрийн албанд томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт" 2. Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас санаачилан Монгол улсын Сангийн яамтай хамтран зохион байгуулсан "Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй" сургалт, УИХ, Сангийн яамтай хамтарсан "Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлтийн тогтолцоо бүрдүүлэх нь" хэлэлцүүлэгт тус тус суралцсан. 3. Сангийн яамнаас зохион байгуулсан "Улсын салбарын дотоод аудиторудыг чадавхжуулах олон улсын туршлага солилцох зөвлөгөөнд 2025 оны 11 дүгээр сарын 13-14-ны өдрүүдэд суралцсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	4.1.2. Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	-	-	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын хөтөлбөрөөр "Монгол бичиг" "Жендерийн эрх тэгш байдал" хичээлийг цахимаар судлан үзсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх зохих сургалтад хамрагдсан байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх зохих сургалтад хамрагдсан байна.	-	-	Удирдлагын академийн "Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт"-нд суралцаж төгссөн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

ХЯНАСАН:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, В Түвшинжаргал /.....
.....

Огноо:

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан шинжээч, Одонмажиг Марина /.....
.....

2025.12.15 Огноо:

